



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Г Т

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Тэнгэр даатгал” ХХК-ийн “Үл хөдлөх хөрөнгийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Байшин барилгын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “… Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Тэнгэр даатгал” ХХК /Ойбек Н.Халилов/-д үүрэг болгосугай.

3. Тус бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Тэнгэр даатгал” ХХК /Ойбек Н.Халилов/, актуарч /Б.Даваасүрэн/-д тус тус анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

F:\ajil 2019\Blank\Togtool.doc

000707

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 12 сарын 09 өдрийн
344-р тогтоолын хавсралт 2

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Тэнгэр даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Байшин барилгын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хөрөнгийн даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгуулагчийн өмчлөл бүхий улсын бүртгэлийн гэрчилгээтэй орон сууц эсвэл амины орон сууц
5.	Даатгалын эрсдэл	<p>1. Байгалийн эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Уерийн аюул; • Цасан болон шороон шуурга; • Газар хөдлөлт; • Аянга; • Аадар бороо. <p>2. Галын эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Гал түймэр; • Тэсрэлт, дэлбэрэлт. <p>3. Цахилгаан эрчим хүчиний эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Хэвийн бус хэлбэлзлийн улмаас үүдэлтэй хохирол учрах; • Хэт ачааллын улмаас хохирол учирах; • Богино холболтоос үүдэлтэй хохирол учрах. <p>4. Сантехникийн ус алдалт.</p>
6.	Даатгалын гэрээний хугацаа	Харилцан тохиролцоно
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	9 бүлэг, 123 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн A/15 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Даваасүрэн
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Андеррайтинг хариуцсан захирал Б.Заяа, Маркетинг, бизнес хөгжлийн хэлтсийн менежер Б.Мөрөн

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 4 сарын 09 өдрийн
344 р тогтоолын хавсралт 1

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Тэнгэр даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Үл хөдлөх хөрөнгийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хөрөнгийн даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгуулагчийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө
5.	Даатгалын эрсдэл	<p>Үндсэн эрсдэл:</p> <ol style="list-style-type: none"> Гал түймэр, дэлбэрэлт /Хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгөнд хохирол учруулах гал түймэр, шаталт, ноцолт, тэсрэлт, дэлбэрэлт/; Байгалийн эрсдэл /Хүчтэй хуй салхи, цасан болон ширүүн мөндөр, үер усны аюул, аадар бороо, газар хөдлөлт, хөрсний овойлт, суулт, нуралт, гулгалт, цөмрөлт, галт уулын дэлбэрэлт, ойн болон хээрийн гал түймэр, аянга цахилгаан гэх мэт/; Ус, чийгийн эрсдэл /сантехникийн ил далд шугам сүлжээ, холбогдсон эд ангийн гэмтэл, хөдлөлт болон даралтаас үүдэн ус алдахыг/; Цахилгаан эрчим хүчний эрсдэл /цахилгааны өндөр хүчдэл, хэт хэлбэлзэл, богино холболт, цахилгаан соронзон нөлөөлөл, цахилгаан шитийн гэмтэл, гал хамгаалагч, хуваарилагч, тусгаарлагчийн гэмтэл, цахилгаан гүйдлийн шууд бус нөлөөлөл/; Цонхны шилний хохирол. <p>Нэмэлт эрсдэл:</p> <ol style="list-style-type: none"> Гуравдагч этгээдийн хорлон сүйтгэх эрсдэл; Хулгай дээрэм, түүнээс үүдэлтэй хохирол; Ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл.
6.	Даатгалын гэрээний хугацаа	Харилцан тохиролцоно
8.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	8 бүлэг, 144 заалт
9.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/14 тоот шийдвэр
10.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Даваасүрэн
11.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Андеррайтинг хариуцсан захирал Б.Заяа, Маркетинг, бизнес хөгжлийн хэлтсийн менежер Б.Мөрөн